



МУЦАЭХ-ны 2025 оны 03 дугаар
сарын 27-ны өдрийн XXVI Их Хурлын
04 тоот тогтоолын хавсралт.

МЭРГЭШЛИЙН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ, МЭРГЭЖИЛТЭНД ЭРХ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

1. НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Шалгаруулалт явуулахтай холбоотой шалгалт, сургалтын төлбөр хураамжийг Холбооны Удирдах зөвлөл тогтооно.

2. ХОЁР. МЭРГЭШЛИЙН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ

- 2.1. Холбоо шалгаруулалт явуулах хуваарийг мэргэшлийн зөвлөлөөр батлуулж, нийтэд мэдээлнэ.
- 2.2. Мэргэшлийн шалгаруулалтыг Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон шалгалтын комисс зохион байгуулна.
- 2.3. Шалгалтын комисс нь мэргэшлийн зөвлөлийн 3 хүртэлх гишүүдээс бүрдэнэ.
- 2.4. Шалгалтын комисс нь дараах үйл ажиллагааг зохион байгуулна.
 - 2.4.1. Шалгаруулалт явуулах шалгалтын эхийг боловсруулах, нууцлалыг хадгалах, хяналт тавих;
 - 2.4.2. Шалгалтын дэг (хавсралт 2)-ийг мөрдүүлэх;
 - 2.4.3. Шалгалтын дүнг нэгтгэж, ажлын 3 өдрийн дотор Мэргэшлийн зөвлөлийн даргад танилцуулах;
 - 2.4.4. Шалгалтын эх, даалгаврын нууцлал задарсан нь тогтоогдсон бол шалгалтын үйл ажиллагааг зогсоох, шалгалтыг дахин авах, шалгалтын хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэх.
- 2.5. Шалгалтын комиссын гишүүдэд дараах зүйлсийг хориглоно.
 - 2.5.1. Үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, мэдээллийн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах;
 - 2.5.2. Эрх горилогчтой ашиг сонирхлын зөрчил үүсгэж амлалт өгөх, бэлэг, шан харамж авах, аль нэг эрх горилогчид давуу байдал үүсгэх үйлдэл гаргах;
 - 2.5.3. Шалгалтын эхийг энэ журамд зөвшөөрснөөс бусад тохиолдолд олшруулах, тараах;
 - 2.5.4. Эрх горилогчийн шалгалтын оноо, дүнг засварлах.
- 2.6. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан эрх олгох шалгалт нь суурь болон мэргэжлийн шалгалтаас бүрдэх бөгөөд дараах журмын дагуу авна.
 - 2.6.1. Мэргэжилтний эрх горилогч нь энэ журмын хавсралт 1-д заасны дагуу суурь шалгалтад тэнцсэн байх бөгөөд мэргэжлийн шалгалтыг үргэлжлүүлэн өгөх эрхтэй байна.
 - 2.6.2. Гүйцэтгэх удирдлага болон хөрөнгө оруулалтын эрх горилогч нь энэ журмын хавсралт 1-д заасны дагуу мэргэжлийн шалгалтад тэнцсэн байна.
- 2.7. Шалгалтад тэнцэх доод үнэлгээ нь 60 хувь байна.
- 2.8. Шалгалтын комиссын шийдвэрээр давтан шалгалт зохион байгуулах ба 40 хувь буюу түүнээс дээш үнэлгээ бүхий эрх горилогчдыг хамруулна.

3. ГУРАВ. МЭРГЭЖИЛТЭНД ЭРХ ОЛГОХ, СУНГАХ

- 3.1. Мэргэшлийн зөвлөл энэ журмын хавсралт 1-д заасан шалгалтад тэнцсэн мэргэжилтэнд шалгалтын комиссын дүгнэлтийг үндэслэн Хорооноос баталсан журамд заасан эрхийг олгоно.
- 3.2. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бүрэлдэхүүнийг томилох журамд заасан эрхийг анх удаа 3 жилээр олгоно.
- 3.3. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бүрэлдэхүүнийг томилох журамд заасан эрхийг дараах нөхцөлөөр сунгана. Үүнд:
 - 3.3.1. Энэ журмын 3.2-т заасны дагуу эрх авсан мэргэжилтэн эрх авснаас хойш 3 жилийн хугацаанд жил бүр 5-аас доошгүй цагийн сургалтад хамрагдаж, эрх сунгах шалгалтад тэнцсэн бол 4 жилээр нэг удаа сунгана.
 - 3.3.2. Энэ журмын 3.3.1-т заасны дагуу эрх сунгасан мэргэжилтэн 4 жилийн хугацаанд жил бүр 5-аас доошгүй цагийн сургалтад хамрагдаж, эрх сунгах шалгалтад тэнцсэн бол 6 жилээр нэг удаа сунгана.
- 3.4. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бүрэлдэхүүнийг томилох журамд заасан эрхийг дараах нөхцөлөөр хугацаагүй олгоно. Үүнд:
 - 3.4.1. Энэ журмын 3.3.2-т заасны дагуу эрх сунгасан мэргэжилтэн 6 жилийн хугацаанд 30-аас доошгүй цагийн сургалтад хамрагдаж, эрх сунгах шалгалтад тэнцсэн бол;
 - 3.4.2. Энэ журмын 3.2-т заасан эрхийг авснаас хойш салбартаа тасралтгүй 13 жил ажилласан, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчиж байгаагүй бол.
- 3.5. Мэргэжилтэн нь эрх сунгах шалгалтыг энэ журмын 3.2-т заасан хугацаанаас өмнө авахгүй.
- 3.6. Мэргэжилтэн нь эрхийн хугацаа нь дууссан бол дараагийн шалгалтыг 6 сарын дотор өгөх үүрэгтэй.

4. ДӨРӨВ. ЭРХ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 4.1. Мэргэшлийн зөвлөл нь дараах үндэслэлээр мэргэжилтний эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.
 - 4.1.1. Салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
 - 4.1.2. Мэргэжилтэн нь ёс зүйн дүрэм зөрчсөн, сахилгын шийтгэл ногдуулсан тухай Холбооны Хяналтын зөвлөлийн шийдвэрийг ирүүлсэн;
 - 4.1.3. Эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотойгоор шүүхэд сэжигтнээр татагдсан.
- 4.2. Мэргэшлийн зөвлөл нь дараах үндэслэлээр мэргэжилтний эрхийг хүчингүй болгоно.
 - 4.2.1. Салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
 - 4.2.2. Түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй;
 - 4.2.3. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон.
- 4.3. Мэргэжилтний эрхийг түдгэлзүүлсэн эсвэл хүчингүй болгосон тухай шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан Холбооны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 4.4. Мэргэшлийн зөвлөл нь зөрчлийг арилгасан тухай нотлох баримт бүхий хүсэлтийг үндэслэн мэргэжилтний эрхийг сэргээнэ.
- 4.5. Энэ журмын 4.2-т заасан шийдвэрт заасан хугацаанд мэргэжилтэнд эрх олгохгүй.

5. ТАВ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 5.1. Холбоо нь Мэргэшлийн зөвлөлийн баталсан хуваарь, хөтөлбөрийн дагуу үргэлжилсэн сургалт зохион байгуулна.

- 5.2. Холбоо нь эрх горилогчийг сургалтын гарын авлага, жишиг тестийн санг цахим хэлбэрээр олгоно.
- 5.3. Холбоо нь энэ журмын 2.6-д заасан шалгалтад бэлтгэх зорилгоор Мэргэшлийн зөвлөлийн баталсан хөтөлбөрийн дагуу дараах сургалтуудыг зохион байгуулна.
Үүнд:
 - 5.3.1. Мэргэжилтний эрх олгох шалгалтад бэлтгэх;
 - 5.3.2. Хөрөнгө оруулалтын эрх олгох шалгалтад бэлтгэх;
 - 5.3.3. Гүйцэтгэх удирдлагын эрх олгох шалгалтад бэлтгэх.
- 5.4. Холбоо нь мэргэжилтнийг эрх сунгах шалгалтад бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор үргэлжилсэн сургалтыг зохион байгуулна.

ХАВСРАЛТ 1

Шалгалтын нэр	Суурь шалгалт	Хөрөнгө оруулалтын мэргэжлийн шалгалт	Хөрөнгө оруулалтын эрх сунгах	Гүйцэтгэх удирдлагын мэргэжлийн шалгалт	Гүйцэтгэх удирдлагын эрх сунгах
Хугацаа	50+ минут	50+ минут	30+ минут	50+ минут	30+ минут
Асуулт	40	40	20	40	20
Суурь шалгалтын хүчинтэй хугацаа	-	6 сар	-	6 сар	-
Шалгалт өгөх шалгуур	Бакалаврын дипломтой байх	Суурь шалгалтад тэнцсэн байх	Журамд заасан хугацааны шаардлага хангасан байх	Суурь шалгалтад тэнцсэн байх	Журамд заасан хугацааны шаардлага хангасан байх

ХАВСРАЛТ 2

Шалгалтын дэг

1. Эрх горилогч нь шалгалт эхлэх цагаас 30-с доошгүй минутын өмнө дараах бичиг баримтыг үндэслэн бүртгүүлж шалгалтын байранд нэвтэрнэ.
 - 1.1. Иргэний үнэмлэх түүнтэй адилтгах бусад бичиг баримт;
 - 1.2. Шаардлагатай тохиолдолд төлбөр төлсөн баримт;
2. Шалгалтын комиссын гишүүн нь шалгалт эхлэхээс 10 минутын өмнө шалгалтын үед дагаж мөрдөх зааврыг эрх горилогчид танилцуулна.
3. Шалгалтын комиссын гишүүн нь шалгалтын битүүмжилсэн хэвлэмэл эхийг эрх горилогчдын өмнө задлах эсвэл цахим эхийг системд тохируулсан байна.
4. Эрх горилогч нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 4.1. Шалгалттай холбоотой асуудлаар шалгалтын комиссоос лавлагаа, мэдээлэл авах;
 - 4.2. Шалгалт эхлэх үед шалгалтад ашиглах компьютер, программ хангамжийн талаар арга зүйн зөвлөгөө авах;
 - 4.3. Шалгалтын үйл ажиллагаатай холбоотой мэргэшлийн зөвлөлд гомдол, санал гаргах;
 - 4.4. Гадаад улсын иргэн шалгалтын эхийг англи хэлээр авах;
 - 4.5. Шалгалтын дүнтэй танилцах.
5. Эрх горилогч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 5.1. Шалгалтад эрх горилогч нь сургалтын цахим бүртгэлийн системд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж илгээнэ.
 - 5.2. Шалгалтад бүртгүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах, шаардсан материалуудыг бүрэн бүрдүүлж өгөх;
 - 5.3. Шалгалтыг хураамж төлөх;
 - 5.4. Шалгалт зохион байгуулагдах газар, шалгалт өгөхөөр мэдэгдсэн хугацаанаас хоцрохгүй ирэх;
 - 5.5. Шалгалтад орохоор ирэхдээ иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бусад баримт бичигтэй байх;
 - 5.6. Шалгалт зохион байгуулагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.
6. Эрх горилогчид дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
 - 6.1. Эрх горилогч нь шалгалт эхэлснээс дуусах хүртэл хугацаанд шалгалтын цахим систем, анги танхимаас гарах, гар утас ашиглах, хоорондоо ярилцахыг хориглоно.
 - 6.2. Эрх горилогч нь шалгалтын явцад шалгалтын комиссын зөвшөөрснөөс бусад ямар нэг техник хэрэгсэл, ном, сурах бичиг, гарын авлага, ноорог цаас болон бусад зүйл авч орох, ашиглах, ашиглахыг завдах, шалгалтын эх, даалгаврыг гүйцэтгэхдээ бусдаас дэмжлэг авах, хуулах, хуулуулах, өөрийнхөө оронд өөр хүн оруулах, баримт бичгийг хуурамчаар үйлдэхийг хориглоно.
 - 6.3. Эрх горилогч нь шалгалтын комиссын гишүүд, хянагч болон бусад эрх горилогч нартай зүй бус харьцахыг хориглоно.
7. Шалгалтын нэгдсэн дүнг мэдээлсний дараа шалгалтын эх, даалгаврын нууцлал задарсан нь тогтоогдсон тохиолдолд түүний үр дүнг ашигласан шалгалтад эрх горилогчийн шалгалтын дүнг хүчингүй болгоно.
8. Эрх горилогчийн буруугаас шалтгаалан бүртгүүлсэн шалгалтдаа хамрагдахгүй 6 сараас дээшгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд сургалтын төлбөр буцааж олгохгүй.